НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

ЧС Чухал Сэдэв
БОДЛОГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

2026 ОНЫ 11 ДҮГЭЭР САР

МОНГОЛ УЛСЫН 2027 ОНЫ НЭГДСЭН ТӨСӨВТ УУЛ УУРХАЙН САЛБАРААС ТӨВЛӨРӨХ ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТӨД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Доктор (Ph.D), профессор Д.Тунгалаг[1]
Доктор (Sc.D), профессор Б.Цэцгээ
С.Цэндбаатар

Эдийн засгийн өсөлт, хөгжил, өрсөлдөх чадварыг хангахад төрийн макро эдийн засгийн бодлого чухал ач холбогдолтой, ялангуяа төсвийн бодлого нь дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) ба үндэсний баялгийн тодорхой хэсгийг хуваарилах, дахин хуваарилах замаар эдийн засгийн нэгжүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, урамшуулж, улмаар стратегийн ач холбогдолтой салбарыг хөгжүүлэх, улс орны эдийн засгийн хөгжлийг хангахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Иймд энэхүү судалгааны ажлын хүрээнд Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсөвт уул уурхайн салбараас орох орлогод нөлөөлөх хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийх, орлогыг бодитой төлөвлөх, төлөвлөсөн орлогыг бүрэн төвлөрүүлэхэд анхаарах асуудлыг тодорхойлохыг зорилоо.

1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГОД УУЛ УУРХАЙН САЛБАРААС ТӨВЛӨРӨХ ОРЛОГО, ТҮҮНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС

Орчин үед улс орнуудын байгалийн баялаг, ашигт малтмалын хэрэгцээ өсөн нэмэгдэж, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт хийж, байгалийн баялгийг олборлох, ашиглах бодлогыг хэрэгжүүлж байна. Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад уул уурхайн салбарыг түлхүү хөгжүүлснээр эдийн засгийн уналт, ядуурал, экологийн сүйрэлд хүрсэн жишээ олон байхад нөгөө талд нь эдийн засгийн өндөр өсөлтийг хангаж, иргэдийн амьжиргааны түвшнийг дээшлүүлсэн улс орнууд нэлээд байна. Уул уурхайн салбарыг улсын хөгжлийн бодлоготой уялдуулан хөгжүүлснээр эдийн засгийн өсөлтөд хүрч, ард түмний амьжиргааны түвшнийг өсгөх боломжтой юм. Манай улсын нэгдсэн төсвийн орлогод уул уурхайн салбараас төвлөрөх орлого, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг гадаад, дотоод гэж ангилан дараах байдлаар авч үзэж болно.

[1] Талархал: Энэхүү дүн шинжилгээг сайжруулах зорилгоор үнэтэй санал, шүүмж өгсөн Нээлттэй Нийгэм форумын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Оюунбадамд талархал илэрхийлж байна.

1.1 ОЛОН УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Дэлхийн улс орнуудын эдийн засгийн гадаад орчны тодорхой бус байдал улам бүр нэмэгдэж байна. Ойрх Дорнод дахь хурцадмал байдал үргэлжилж, Ормузын хоолойгоор хийх тээвэрлэлт хумигдвал бүс нутгийн тогтворгүй байдал нэмэгдэж, эдийн засгийн хүндрэл, хямрал үүсэж болзошгүй. Түүнчлэн ОХУ, Украины хоорондох зэвсэгт мөргөлдөөн, дроны дайралт эрчимжиж, ОХУ-ын нефть боловсруулах байгууламжуудын хүчин чадал буурсан нь геополитик, нефтийн зах зээлийн нөхцөл байдалд томоохон эрсдэлийг үүсгээд байна.

Геополитикийн хурцадмал байдал хүлээлтээс удаан үргэлжлэх төлөвтэй байгаа тул дэлхийн инфляцын төсөөлөл өмнөхөөс нэмэгдэнэ. Геополитикийн тогтворгүй байдал, худалдааны дайны нөхцөл байдалтай холбоотойгоор дэлхийн тодорхой бус байдлын индекс (World Uncertainty Index) түүхэн дээд түвшинд хүрсэн байна. Энэ индекс нь улс орнуудын эдийн засаг, улс төр, нийгмийн ирээдүйн талаарх тодорхой бус байдал хэр их байгааг хэмжихэд ашигладаг үзүүлэлт бөгөөд тухайн улсын эдийн засаг муу эсвэл сайн байгааг шууд хэмждэггүй. Харин ирээдүйн нөхцөл байдлын талаар хэр их тодорхой бус байдал, эргэлзээ байгааг илэрхийлдэг.


Зураг 1. Дэлхийн тодорхой бус байдлын индекс



Эх сурвалж: www.econovist.net

Дээрх нөхцөл байдалтай холбоотойгоор Олон улсын валютын сан дэлхийн эдийн засгийн 2026 оны өсөлтийн төсөөллийг 3.3 хувиас 3.0 хувь болгож, Дэлхийн банк эдийн засгийн төсөөллийг 2.7 хувиас 2.4 хувь болгон тус тус бууруулаад байна.

Зураг 2. Улс орнуудын өсөлтийн төсөөлөл, 2025–2027 он



Эх сурвалж: Блүүмберг, EIU, ОУВС, DISR, Фокус экономикс зэрэг олон улсын байгууллагуудын төсөөллийн дундаж

БНХАУ-ын 2026 оны II улирлын эдийн засгийн өсөлт жилийн 4.3 хувьд хүрч өмнөх улирлаас саарав. Үүнд дотоод эрэлт сул байсны зэрэгцээ үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт үргэлжилж, үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт сүүлийн дөрвөн улирал дараалан агшсан нь нөлөөлжээ. БНХАУ-ын өсөлт цаашид саарах төсөөлөл хэвээр байна. Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн хямрал үргэлжилж, өрхийн хэрэглээ сул хэвээр байх хүлээлттэй байна. Түүнчлэн АНУ болон Евро бүсийн орнууд БНХАУ-ын хагас дамжуулагч, цахилгаан автомашинд тарифын арга хэмжээ авч болзошгүй байна. Улмаар эдийн засгийн өсөлт ирэх онд алгуур саарах төлөвтэй.

ОХУ-ын 2026 оны II улирлын эдийн засгийн өсөлт жилийн 1.3 хувьд хүрч өмнөх улирлаас нэмэгдэв. Энэхүү өсөлтөд батлан хамгаалах чиглэлийн төсвийн зарцуулалт, зэвсгийн үйлдвэрлэл, тус салбарын худалдан авалт эрс нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. ОХУ-ын газрын тос боловсруулах байгууламж руу чиглэсэн Украйны дроны дайралтууд эрчимжиж, бүс нутгуудад шатахууны нийлүүлэлт бууран үнэ өссөнөөр 8-р сард инфляц 6.3 хувьд хүрч нэмэгдэв. Олон улсын судалгааны байгууллагуудын тооцооллоор ОХУ-ын нефть боловсруулах хүчин чадал хэвийн үетэй харьцуулахад 30 орчим хувиар буураад байна.

1.2 МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛД УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

Монгол Улсын уул уурхайн салбар нь стратегийн ач холбогдолтой салбарын нэг болох ба эдийн засгийн өсөлт, хөгжлийг хангахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд чухал хувь нэмэр оруулах учиртай юм.

Зураг 3. ДНБ, уул уурхайн салбарын өсөлт, хувиар



Эх сурвалж: https://www.1212.mn

Манай улсын ДНБ-ний өсөлтөд дэлхийн зах зээл болон дотоод нөхцөл байдал, уул уурхайн салбарын өсөлт ихээхэн нөлөөтэй байна. ДНБ 2025 онд нэрлэсэн дүнгээр 89.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 11.5 хувиар, бодит дүнгээр 34.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар тус тус өслөө.

Эдийн засгийн бүтцийг авч үзвэл сүүлийн таван жилд уул уурхай, тээвэр, санхүү, даатгалын салбарын эзлэх хувь нэмэгдэж, мэдээлэл холбоо, худалдааны салбарын эзлэх хувь тогтвортой байна. Харин хөдөө аж ахуй, боловсруулах, барилга, эрчим хүчний салбарын эзлэх хувь буурсан байна.

Зураг 4. Эдийн засгийн бүтэц, 2025 он, хувиар



Эх сурвалж: https://www.1212.mn

Өнөөдөр манай улсын ДНБ-ний 23-28 хувийг уул уурхайн салбар, 6.8-8.6 хувийг боловсруулах аж үйлдвэр, 1.4-2 хувийг цахилгаан, дулааны салбар бүрдүүлж, уул уурхайн салбарын эдийн засагт гүйцэтгэх үүрэг нь улам бүр өсөн нэмэгдэж байна.

Хүснэгт 1. Уул уурхайн ба уул уурхайн бус салбарын өсөлт, тэрбум төгрөг


	2021	2022	2023	2024	2025
Нэрлэсэн ДНБ (үйлдвэрлэлийн аргаар)	43,555	53,852	70,442	80,663	89,937
Бодит ДНБ (үйлдвэрлэлийн аргаар)	27,092	28,455	30,567	32,133	34,332
	(өсөлт, хувиар)				
Бодит ДНБ-ий өсөлт	1.6	5.0	7.4	5.1	6.8
Уул уурхайн	0.8	-15.3	23.4	10.8	6.8
Уул уурхайн бус	1.8	8.2	5.4	4.3	6.3

Эх сурвалж: Макро эдийн засгийн танилцуулга, Эдийн засаг хөгжлийн яам, 2025 он, хуудас 85

Уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн хэмжээ 2021-2025 оны дунджаар 17.5 их наяд төгрөгт хүрч, уул уурхайн салбарын өсөлт 2024 онд 10.8 хувь, 2025 онд 6.8 хувьд хүрсэн байна. Уул уурхайн салбар оны эхний хагаст 1.1 хувийн өсөлттэй байсан бол нүүрсний экспортын хэмжээ оны сүүл хэсэгт нэмэгдсэний нөлөөгөөр сэргэлээ. Түүнчлэн зэсийн баяжмалын үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 36 хувиар, тухайлбал Оюу толгойн гүний уурхайн олборлолтын нөлөөгөөр оны эхний гурван улиралд 42.2 хувиар өссөн нь уул уурхайн салбарын өсөлтийг дэмжсэн байна.

Үндэсний үйлдвэрлэлийн түвшин нь улс орны хэмжээнд хуримтлагдсан капитал, хөрөнгө оруулалт, технологийн хөгжил болон хэрэгжүүлж буй эдийн засгийн бодлогын нөлөөллөөс хамаардаг. Иймд хөрөнгө оруулалтын бодлогын үр ашгийг дээшлүүлэх асуудал эдийн засгийн хөгжлийг хангахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

Зураг 5. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал (тэрбум, ам.доллар)



Эх сурвалж: Макро эдийн засгийн танилцуулга, Эдийн засаг хөгжлийн яам, 2025 он, хуудас 81

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалын судалгаанаас харвал нийт гадаадын хөрөнгө оруулалтын 80 орчим хувь нь уул уурхайн салбарт орсон байна.

Манай улс байгалийн нөөц баялаг арвин, хоёр хөрш орон төдийгүй дэлхийн бусад орныг шаардлагатай түүхий эдээр хангах боломжтой, газар зүйн байршлын хувьд хоёр том зах зээлийн дунд оршиж, түүгээр дамжин гадаад зах зээлд хүрэх давуу талтай байна. Энэ нь Монгол Улсад дэлхийн томоохон улс орнууд болон үндэстэн дамнасан корпорацуудын ашиг сонирхлыг бий болгож байна. Дэвшилтэт техник, технологийг боловсруулах үйлдвэрлэлд нэвтрүүлэх замаар байгалийн баялаг, түүхий эдийг боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хүнд, хөнгөн үйлдвэрлэлийн цогцолборыг барьж байгуулах, эрчим хүчний салбарыг хөгжүүлэх, олон улсын зам тээврийн сүлжээнд холбогдох замаар үндэсний эдийн засгийн өсөлт хөгжлийг хангах бүрэн боломжтой юм.

1.3 УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГЫН ӨСӨЛТИЙН ХУРД

Нэгдсэн төсвийн нийт орлого цар тахлын өмнө буюу 2019 онд 12.0 их наяд төгрөг буюу ДНБ-ий 31.8 хувь, нийт зарлага 11.7 их наяд төгрөг буюу ДНБ-ий 30.8 хувьтай байсан бол уул уурхайн салбарын өсөлтийг даган сүүлийн 5 жилд тэлж, 2025 онд төсвийн орлого 32.6 их наяд төгрөг буюу ДНБ-ий 36.3 хувьд, төсвийн зарлага 31.3 их наяд төгрөг буюу ДНБ-ий 34.8 хувьд хүрч, 2019 онтой харьцуулахад ойролцоогоор 3 дахин өссөн үзүүлэлттэй байна.


Зураг 6. Уул уурхайн салбарын орлогын өсөлтийн хувь, 2025 он



Эх сурвалж: Макро эдийн засгийн танилцуулга, Эдийн засаг хөгжлийн яам, 2025 он, хуудас 18

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2025 онд 32.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.8 хувиар өссөн хэдий ч 2024 оны төсвийн орлогын өсөлттэй харьцуулахад 25.2 нэгж хувиар буурсан байна.

Зураг 7. ДНБ-д нийт орлого, хөрөнгийн зардал, урсгал зардлын эзлэх жин, хувь



Эх сурвалж: Макро эдийн засгийн танилцуулга, Эдийн засаг хөгжлийн яам, 2025 он, хуудас 34


Нэгдсэн төсвийн нийт орлого уул уурхайн салбарын өсөлтийг даган сүүлийн 5 жилд тэлж, 2025 онд төсвийн орлого 32.6 их наяд төгрөг буюу ДНБ-ий 36.3 хувьд хүрч, төсвийн зарлага 2021-2025 онд жилд дунджаар 18.1 хувиар өсөж, 2025 онд 31.3 их наяд төгрөг буюу ДНБ-ий 34.8 хувьд хүрсэн байна.

Уул уурхайн салбарын үйл ажиллагаа харьцангуй идэвхэжсэн хэдий ч нүүрсний үнийн уналтаас шалтгаалан аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ) болон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ)-ын орлого буурчээ. Нүүрсний экспортын биет хэмжээ нэмэгдсэн хэдий ч оны эхнээс үргэлжилсэн нүүрсний үнийн уналтаас шалтгаалан уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагаа саарч, татварын орлогын төвлөрүүлэлт өмнөх оны мөн үеэс буурахад нөлөөлсөн байна.

1.4 УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГОД УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ЭЗЛЭХ ЖИН

Нийт татварын орлогын хэмжээ 2025 оны байдлаар 17,923.20 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнээс 8,810.10 тэрбум төгрөг буюу 49.2 хувийг эрдэс баялгийн салбар бүрдүүлж, гол нэр төрлийн түүхий эд нүүрсний үнийн уналт болон татвар, хураамж, ногдол ашиг бүрэн төвлөрөөгүйгээс шалтгаалан татварын орлого 12 хувиар буурсан байна.

Зураг 8. Татварын орлогын харьцаа, эзлэх хувийн жингээр, 2020–2025 он



Эх сурвалж: Эрдэс баялгийн салбарын бүтээгдэхүүний 2025 оны тойм судалгаа, Том татвар төлөгчдийн газар, хуудас 6

2025 онд татварын нийт орлого өмнөх оноос 637.8 тэрбум төгрөгөөр өссөн бол нийт татварын орлогод эрдэс баялгийн салбарын эзлэх хувь 9.1 нэгж хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Эрдэс баялгийн салбараас төвлөрүүлсэн татварын орлогын мэдээ, татварын төрлөөр, тэрбум төгрөг

	Татварын төрөл	2024		2025		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүнгээр	Хувиар
	Эрдэс баялгийн салбарын татварын нийт орлого	10,061.10	100	8,810.08	100.00	(1,251.02)	(12.43)
1	Улсын төсвийн орлого	9,179.70	91.2	7,786.72	88.38	(1,392.98)	(2.82)
1.1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	3,744.50	37.2	2,790.04	31.67	(954.46)	(5.53)
1.2	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	4,674.80	46.5	4,346.21	49.33	(328.59)	2.83
1.3	Дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ	237.5	2.4	374.72	4.25	137.22	1.85
1.4	Бусад	522.8	5.2	275.75	3.13	(247.05)	(2.07)
2	Орон нутгийн төсвийн орлого	881.5	8.8	1,023.36	11.62	141.86	16.09
2.2	ҮХХАТ	212	2.1	290.16	3.29	78.16	36.87
2.3	Усны төлбөр	68.37	0.7	77.18	0.88	8.81	12.88
2.4	Цалин хөлснөөс суутгасан татвар /ХХОАТ/	284	2.8	409.91	4.65	125.91	44.33
2.6	Бусад	317.08	3.2	246.12	2.79	(70.96)	(22.38)

Эх сурвалж: Эрдэс баялгийн салбарын бүтээгдэхүүний 2025 оны тойм судалгаа, Том татвар төлөгчдийн газар, хуудас 7


Улсын төсөвт 2025 онд төвлөрүүлсэн татварын орлогыг өмнөх онтой татварын төрлөөр нь харьцуулахад ААНОАТ-ын орлого 5.53 хувиар, АМНАТ-ын орлого 2.83 хувиар буурсан бол НӨАТ-ын орлого 1.85 хувиар өсжээ.

Хүснэгт 3. Эрдэс баялгийн салбараас улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээ, ашигт малтмалын төрлөөр

		2024		2025		Өөрчлөлт	
	Ашигт малтмалын төрлөөр	Төвлөрүүлсэн татвар	Хувь	Төвлөрүүлсэн татвар	Хувь	Дүнгээр	Хувиар
	Нийт	10,061.10	100	8,810.08	100.00	-1,251.02	-12.850
1	Зэс	2,311.40	23	3,499.53	39.7	1,188.13	51.403
2	Нүүрс	6,749.40	67.1	3,766.69	42.8	-2,982.71	-44.192
3	Алт	375.4	3.7	579.94	6.6	204.54	54.487
4	Төмөр	158.9	1.6	422.81	4.8	263.91	166.086
5	Цайр	96.5	1	172.68	2.0	76.18	78.944
6	Бусад	369.5	3.7	368.43	4.2	-1.07	0.290

Эрдэс баялгийн салбараас улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын мэдээнээс үзвэл татварын орлогын 42.8 хувийг нүүрснээс, 39.7 хувийг зэсийн баяжмалаас төвлөрүүлсэн орлого тус тус эзэлж байна.

Зураг 9. Эрдэс баялгийн салбараас улсын төсөвт төвлөрүүлсэн орлого, ашигт малтмалын төрлөөр, тэрбум төгрөг



Эх сурвалж: Эрдэс баялгийн салбарын бүтээгдэхүүний 2025 оны тойм судалгаа, Том татвар төлөгчдийн газар, хуудас 7

2024 онтой харьцуулбал 2025 онд зэсийн орлого 51 хувиар өссөн боловч нүүрсний орлого 44 хувь, нийт орлого 12.8 хувиар тус тус буурсан байна.

1.5 УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Уул уурхай, олборлох салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл сүүлийн жилүүдэд өсөж байна.

Хүснэгт 4. Нүүрсний олборлолт, экспортын мэдээ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021	2022	2023	2024	2025	Өөрчлөлт хувиар 2025/2024
Олборлолт	мян.тн	30,124.3	37,207.7	81,191.9	97,721.5	95,450.6	2.3
Экспорт	мян.тн	16,166.5	31,821.6	66,708.5	83,737.10	89,708.0	7.1
Үнийн дүн	мян.ам $	2,779,459.1	6.503.248.2	8,764,106.0	8,697,900.1	5,749,986.6	33.9

Эх сурвалж: Эрдэс баялгийн салбарын бүтээгдэхүүний 2025 оны тойм судалгаа, Том татвар төлөгчдийн газар, хуудас 10

2025 онд нүүрсний олборлолт өмнөх оноос 2.3 хувиар буурч, экспортын хэмжээ 7.1 хувиар өссөн боловч нүүрсний үнийн уналтаас шалтгаалан орлого 33.9 хувиар буурчээ.

Хүснэгт 5. Нүүрс экспортлогч голлох аж ахуйн нэгжүүдийн экспортын хэмжээ /мян.тн/

№	Экспортлогчийн нэр	2021	2022	2023	2024	2025	Эзлэх хувь
1	Эрдэнэс Таван Толгой ХК	6,131.90	13,549.30	28,634.61	30,462.50	28,628.32	31.99
2	Таван Толгой ХК	730.5	3,104.00	2,368.50	3,134.05	2,262.00	2.53
3	Монголын алт МАК ХХК	1,612.90	2,912.18	7,457.87	9,953.42	14,342.63	16.02
4	Энержи Ресурс ХХК	1,072.60	3,621.50	7,925.24	6,786.95	6,779.59	7.57
5	Саусгоби сэндс ХХК	1,309.60	1,294,18	3,554.13	7,475.99	11,008.81	12.30
6	Моэнко ХХК	1,154,45	2,204,45	2,574.87	3,089.12	2,852.43	3.19
7	Бусад ААН	5,309.00	8,627.02	17,364.78	22,835.07	52,256.58	58.39
	Нийт	16,166.50	31,814.00	69,880.00	83,737.10	89,502.04	100%

Эх сурвалж: Эрдэс баялгийн салбарын бүтээгдэхүүний 2025 оны тойм судалгаа, Том татвар төлөгчдийн газар, хуудас 10

Нүүрс экспортлогч голлох аж ахуйн нэгжүүдийн экспортын хэмжээг авч үзвэл Эрдэнэс таван толгой компани 31.99 хувь, Монголын алт компани 16 хувь, Саусгоби сэндс компани 12.3 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 6. Зэсийн баяжмалын үйлдвэрлэл, экспорт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021	2022	2023	2024	2025
Олборлолт	мян.тн	1,326.3	1,189.8	1 395.3	1,395.3	2,126.6
Экспорт	мян.тн	1,282.5	1,453.5	1,524.8	1,695.4	2 281.9
	мян.ам $	2,899,857.3	2,734,846.2	2,265,686.4	3,319,118.1	5,808,741.1

Эх сурвалж: Эрдэс баялгийн салбарын бүтээгдэхүүний 2025 оны тойм судалгаа, Том татвар төлөгчдийн газар, хуудас 32

Манай улс 2025 онд 2.1 сая тонн зэсийн баяжмал үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 52.4 хувиар өссөн байна. Нийт зэсийн экспортын 72 хувийг Оюу толгой компани, 27 хувийг Эрдэнэт үйлдвэр гаргажээ.

Хүснэгт 7. Зэс экспортлогч голлох аж ахуйн нэгжүүдийн экспортын хэмжээ /мян.тн/

№	Экспортлогчийн нэр	2019	2020	2021	2022	2023	2025	Эзлэх хувь
1	Оюутолгой ХХК	763.8	746.2	706.7	772.2	860.69	1,643.57	72.12
2	Эрдэнэт ХХК	639.8	648.9	575.8	681.3	665.59	635.169	27.87
3	Бусад						0.20	0.01
Нийт тоо хэмжээ		1,403.60	1,395.10	1,282.50	1,453.50	1,526.28	2,278.94	100.00


Эх сурвалж: Эрдэс баялгийн салбарын бүтээгдэхүүний 2025 оны тойм судалгаа, Том татвар төлөгчдийн газар, хуудас 10, 32

2025 онд татвар төлөлтөөрөө Эрдэнэт үйлдвэр төрийн өмчийн үйлдвэрийн газар, Эрдэнэс Таван толгой компани, Оюу Толгой компани, Монголын алт компани, Энержи Ресурс компани тэргүүлж байна. Дээрх судалгаанууд нь уул уурхайн салбар Монгол Улсын төсвийн орлогын чухал эх үүсвэр болохыг харуулж байгаа юм.

1.6 ЭКСПОРТЫН ЧИГ ХАНДЛАГА


2025 оны байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлт 27.2 тэрбум ам.долларт хүрч, 4.4 тэрбум ам.долларын ашигтай гарсан. Экспорт 15.8 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеийн түвшинд хадгалагджээ.

Зураг 10. Экспортын бүтэц, 2025 он, хувь



Экспортын бүтээгдэхүүний 37 хувийг зэсийн баяжмал, 35.4 хувийг чулуун нүүрс, 7.9 хувийг алт, 1.2-2.1 хувийг бусад ашигт малтмал тус тус бүрдүүлж байна.

Зураг 11. Экспортын улс орны бүтэц, 2025 он



Эх сурвалж: https://gaali.mn/statistic

Манай улсын экспортын бүтцэд байгалийн баялаг, түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүн 90 гаруй хувийг эзэлж, түүний 90 орчим хувийг БНХАУ руу экспортолж байгаагаас үзэхэд манай улсын экспортын орлого БНХАУ-ын эдийн засгийн өсөлтөөс ихээхэн хамааралтай байна.

1.7 ЭКСПОРТЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ТӨЛӨВ

Баяжуулсан коксжих нүүрсний олон улсын үнэ сүүлийн 3 жилд буурч, 2025 онд 120 ам доллart хүрсэн. Харин зэсийн үнэ эрэлт хэрэгцээний өсөлттэй холбоотойгоор 2025 онд 9648 ам доллар, 2026 оны 9 сарын байдлаар 14300 ам.долларт хүрч өсөөд байна.

Зураг 12. Зэс, нүүрсний үнэ, ам.доллар



Эх сурвалж: Макро эдийн засгийн танилцуулга, Эдийн засаг хөгжлийн яам, 2025 он, хуудас 46

Лондоны металлын бирж дээрх цэвэр зэсийн дундаж үнэ 2025 онд 9,648 ам.доллар болж өссөн. Харин 2026 оны эхний 3 сарын байдлаар цэвэр зэсийн дундаж үнэ 12,979 ам.доллар болж, өмнөх оноос 30.5 хувиар өссөн байна. Индонези, Чили улсад байрлах зэсийн томоохон уурхайнуудын үйл ажиллагаа ослын улмаас доголдож, зэсийн нийлүүлэлт буурсан нь оны эхэнд дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ өсөхөд нөлөөлсөн байна. Дунд хугацаанд цахилгаан эрчим хүч болон технологид суурилсан салбаруудын өсөлтөөс шалтгаалан зэсийн эрэлт нэмэгдэж, үнэ өсөх хүлээлттэй байна.

Австралийн сайн чанарын коксжих нүүрсний дундаж үнэ 2025 онд 119 ам.доллар болж буурсан байна. Харин 2026 оны эхний 3 сарын байдлаар 233 ам.доллар болж, өмнөх оноос 23.6 хувиар өсжээ. Австрали улсад их хэмжээний бороо орсноос шалтгаалан уурхай, тээвэр логистикийн үйл ажиллагаа доголдож, мөн уурхайн засвар үйлчилгээний саатлууд давхацсанаар нийлүүлэлт богино хугацаанд хумигдаж, үнэ өссөн гэж судлаачид үзэж байна.

2. 2027 ОНЫ НЭГДСЭН ТӨСӨВТ УУЛ УУРХАЙН САЛБАРААС ӨВЛӨРӨХ ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ

2027 оны нэгдсэн төсвийн төсөлд төсвийн нийт орлого 45.7 их наяд, тэнцвэржүүлсэн орлого 41.28 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн алдагдал 2.3 их наяд төгрөг байхаар төлөвлөжээ. Төсвийн нийт орлого 2026 оны төсөвт тусгасан дүнгээс 9.5 их наяд төгрөгөөр өсөхөөр байна.


Хүснэгт 8. 2027 оны нэгдсэн төсвийн нийт орлого (тэрбум төгрөг) 2025

ҮЗҮҮЛЭЛТ	2025	2026 ТОД	2027 ТӨС	ЗӨРҮҮ
Нийт орлого ба тусламжийн дүн	33,179.2	**36,172.2**	45,744.0	9,571.8
Тогтворжуулалтын сан	562.5	826.8	483.8	-343.0
Ирээдүйн өв сан	1,710.6	2,886.5	3,277.9	391.4
Хуримтлалын сан	603.0	528.9	702.4	173.4
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	30,303.2	31,930.0	41,280.0	9,350.0

Төсвийн тогтворжуулалтын санд 483.8 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 3.27 их наяд төгрөг, Хуримтлалын санд нийт 702.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр тусгажээ.

2027 онд эдийн засгийн өсөлт 5.1 хувь, нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн 115.3 их наяд төгрөгт хүрч, гол нэр төрлийн эрдэс баялгийн экспортын биет хэмжээ нэмэгдэхээр байгаа нь татварын орлого өсөхөд гол нөлөө үзүүлнэ. Уул уурхайн салбарын өсөлттэй уялдуулан татварын орлого 33 их наяд төгрөгт хүрч, энэ оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 13.6 хувиар өсөхөөр төлөвлөсөн байна.

Зураг 13. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого, тэрбум төгрөг



Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн төслийн баримт бичиг

2024 оноос хойш аж ахуйн нэгжийн орлогын албан татварт уул уурхайн салбарын орлогын эзлэх жин буурч, 2027 онд 51 хувьд хүрнэ гэсэн төсөөлөлтэй байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 2027 онд 7.9 их наяд төгрөгт хүрэхээр байгаа бөгөөд үүнээс 78.2 тэрбум төгрөгийг Төсвийн тогтворжуулалтын санд, 7.8 их наяд төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт тус тус төвлөрүүлэхээр тооцжээ.

Засгийн газар уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч, боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх, төмөр замын ажлыг эрчимжүүлснээр нүүрсний экспортыг 110 сая тонн, зэсийн баяжмалын экспортыг 2.1 сая тоннд хүргэхээр тооцсон.

Олон улсын зах зээлийн төлөв байдалд үндэслэн нүүрсний зах зээлийн дундаж үнийг 68 ам.доллар, зэсийн үнийг 12700 ам.доллар байхаар төсөөлжээ.

ААНОАТ, АМНАТ, хувьцааны ногдол ашгийн орлого, уул уурхайн бүтээгдэхүүний биет хэмжээ өсөх нь татварын орлогын өсөлтөд нөлөөлнө гэж үзсэн байна. Харин 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаас үзэхэд уул уурхайн экспортын гол нэр төрлийн түүхий эдийн үнэ буурсан, ногдуулсан татвар, хураамж бүрэн төвлөрөөгүй, төсөвт төвлөрүүлэх орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүй, ногдол ашгийг бүрэн төвлөрүүлээгүй зэргээс шалтгаалан төсвийн нийт орлого төлөвлөснөөс 2.7 хувь буюу 937.6 тэрбум төгрөгөөр тасарсан гэж дүгнэсэн байна.

Гадаад орчны тогтворгүй байдал үргэлжилж, дэлхийн эдийн засгийн өсөлт удааширч, Монгол Улсын худалдааны гол түнш болох БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарах төлөвтэй байгаагаас үүдэн манай улсын экспортын голлох бүтээгдэхүүн болох нүүрс, зэсийн баяжмалын үнэ болон эрэлт буурснаар төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байх эрсдэл үүсэж болзошгүй. Уул уурхайн салбарын орлого эрчимтэй өсөх мөчлөг үргэлжилнэ гэсэн төсөөлөлд тулгуурлан төлөвлөснийг анхаарах шаардлагатай байна.

Монгол Улсын татварын албаны мэдээллээр 2025 оны байдлаар нийт 72 мянга гаруй татвар төлөгч 6.1 их наяд төгрөгийн татварын өртэй байна. Нийт татварын өрийн 30 гаруй хувь нь уул уурхайн салбарын ойролцоогоор 1000 татвар төлөгчид ногдож байсныг Татварын ерөнхий газрын дарга мэдээлсэн байна[1].

Татварын бус орлогыг 2027 онд энэ оноос 5.4 их наяд төгрөгөөр өсгөж, 8.2 их наяд төгрөгт хүргэхээр төлөвлөсөн нь түүхэн өндөр үзүүлэлт болж, үүнээс 6.7 их наяд төгрөг буюу 81.1 хувийг ногдол ашгийн орлогоор, 483.5 тэрбум төгрөг буюу 5.8 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор, 408.1 тэрбум төгрөг буюу 4.9 хувийг тусламжийн орлогоор, 228.3 тэрбум төгрөг буюу 2.8 хувийг газрын тосны орлогоор тус тус бүрдүүлэхээр байна. Оюу толгой төслийн Монголын төрийн эзэмшлийн хувьцаанд ногдох ногдол ашгаас 2 их наяд төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр тооцсон байсныг өөрчилж, хуримтлалын санд төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн.

Төсвийн эрсдэлийн шинжилгээний тайланд төрийн өмчийн аж ахуйн нэгжүүд 2025 онд улсын төсөвт 5.5 их наяд төгрөгийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оноос 10 хувиар буурсан гэж тусгасан байна. Үүнд ААНОАТ-ын орлого 31 хувь, АМНАТ-ын орлого 9 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн бөгөөд нүүрсний үнийн бууралтаас үүдэн уул уурхайн салбарын орлого буурсан байна. Мөн төрийн өмчийн аж ахуйн нэгжүүд 1.1 их наяд төгрөгийн ногдол ашиг хуваарилсан нь өмнөх оноос 69 хувиар буурсан үзүүлэлт болсон байна. Төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тогтвортой байдал, үйл ажиллагааны үр ашиг болон төсөвт учирч болзошгүй эрсдэлийг ОУВС-ийн загвараар үнэлж үзэхэд төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн 60 орчим хувь нь дундаас дээгүүр болон өндөр эрсдэлтэй түвшинд байна.

Ойрх Дорнодын мөргөлдөөний хурцадмал байдал үргэлжилж газрын тосны үнэ суурь төсөөллөөс 20 хувиар өснө гэж үзвэл 2027 онд баррель нь 84 ам.долларт хүрч, дизель түлшний дотоодын үнэ 21 хувиар өсөхөөр байна. Энэ нь аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны мөнгөн зардлыг өсгөх замаар ашигт ажиллагаа, улмаар уул уурхайн салбарын татварын орлогыг бууруулж болзошгүй. Иймд манай улсын 2027 оны төсвийн орлого бүрдэхэд гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөө хүчтэй байгааг анхаарах шаардлагатай юм.

[1] https://bloombergtv.mn/news/mj27xg

3. УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН SWOT ШИНЖИЛГЭЭ

Улсын нэгдсэн төсвийн орлогод уул уурхайн салбараас төвлөрөх орлого, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг судлан шинжилсний дүнд SWOT шинжилгээ хийж давуу тал, боломж, сул тал, аюул заналыг дараах байдлаар тодорхойлж байна.

S — Strengths (Давуу тал)	W — Weaknesses (Сул тал)
• ДНБ-ний өсөлт эерэг хандлагатай • Уул уурхай болон бусад салбарын өсөлтийн хурд нэмэгдэх хандлагатай • Зэс, нүүрс, алт зэрэг ашигт малтмалын нөөцтэй • Дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ өсөх хандлагатай • Татварын олон төрлийн эх үүсвэр, төсвийн эрх зүйн зохицуулалттай • Уул уурхайгаас гадна боловсруулах үйлдвэр, хөдөө аж ахуй, үйлчилгээний салбар, дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх боломжтой • Эдийн засгийн өсөлтийг төсвийн орлого болгон хувиргах боломжтой	• ДНБ-д уул уурхайн салбарын эзлэх жин өндөр • Эрдэс баялгийн салбарын нийт татварын орлогод эзлэх хувь буурсан • Дэлхийн зах зээл дээр нүүрсний үнэ буурах хандлагатай • Улсын нэгдсэн төсвийн орлогын өсөлтийн хурд саарах хандлагатай • Төсвийн орлого уул уурхайн мөчлөгөөс ихээхэн хамааралтай • Орлогын тасалдал үүсэхэд төсвийн тодотгол хийх шаардлага гардаг • Төсвийн төлөвлөлт, хэрэгжилтийн хооронд зөрүү үүсэх эрсдэлтэй • Эрчим хүч, зам тээврийн салбарыг хөгжүүлэх шаардлагатай
O — Opportunities (Боломж)	**T — Threats (Аюул занал)**
• Уул уурхай, олборлох салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг өсгөх • Гадаадын хөрөнгө оруулалтын эдийн засагт оруулах үр өгөөжийг өсгөх • Уул уурхайн орлогоор хөрөнгө санхүүгийн нөөц бүрдүүлэх • Уул уурхайн бус салбарын татварын баазыг өргөжүүлэх • Бусад төрлийн ашигт малтмалаас орох орлогыг цаашдаа өсгөх • Дэд бүтэц, боловсруулах үйлдвэрлэл, мал аж ахуй, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх • Төсвийн нээлттэй өгөгдөл, гүйцэтгэлийн үнэлгээг хөгжүүлэх	• Гадаад эдийн засгийн орчны тодорхой бус байдал • Глобал инфляцын төсөөлөл өндөр • БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарсан • Уул уурхайн салбар гадаадын хөрөнгө оруулалтаас хамааралтай • БНХАУ-ын эрэлт, худалдааны нөхцөл муудах • Инфляц, төгрөгийн ханшийн дарамт нэмэгдэх • Улс төрийн мөчлөгөөс шалтгаалсан орлого, зардлын өөрчлөлт • Байгалийн гамшиг, зуд, уур амьсгалын эрсдэл

Улсын нэгдсэн төсвийн SWOT шинжилгээний үр дүнгээс үзвэл манай улс зэс, нүүрс, алт зэрэг ашигт малтмалын нөөцтэй, дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ өсөх хандлагатай, уул уурхайн салбараас орох орлогоор эрчим хүч, зам тээврийн салбар, боловсруулах үйлдвэр, хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарыг хөгжүүлэх давуу талтай. Цаашид уул уурхай, олборлох салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өсгөх, уул уурхайн салбарын орлогоор хөрөнгө санхүүгийн нөөц бүрдүүлэх боломжтой байна.

Харин ДНБ-д уул уурхайн салбарын эзлэх жин өндөр, нийт татварын орлогод эрдэс баялгийн салбарын эзлэх хувь буурсан, нүүрснээс орох орлого буурах хандлагатай, төсвийн орлого уул уурхайн мөчлөгөөс ихээхэн хамааралтай, төсвийн төлөвлөлт, хэрэгжилтийн хооронд зөрүү үүсэх магадлалтай байгаа нь сул тал болж байна. Мөн эдийн засгийн гадаад орчны


тодорхой бус байдал нэмэгдэх, хөрш орнуудын эдийн засгийн өсөлт саарах, гадаадын хөрөнгө оруулалтаас уул уурхайн салбар хамааралтай байх, инфляц, төгрөгийн ханшийн дарамт нэмэгдэх, улс төрийн мөчлөгөөс шалтгаалсан орлого, зардлын өөрчлөлт бий болох, байгалийн гамшиг, зуд, уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлтэй байгааг анхаарах шаардлагатай юм.

4. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН СИСТЕМ ДИНАМИКИЙН ЕРӨНХИЙ ЗАГВАР

Орчин үед математик загварчлалын аргуудыг эдийн засгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтөд ашигласнаар эдийн засгийг хөгжүүлэх арга хэрэгслийг тогтоох, түүний үр дүн, эрсдэлтэй талыг үнэлэх, асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох боломжтой болдог. Систем динамик загварчлал нь математикийн онол, арга зүй, Vensim программ хангамжийн тусламжтайгаар өнөөгийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, ирээдүйн чиг хандлага, эрсдэлт нөхцөл байдлыг тооцоолох, янз бүрийн бодлого, шийдвэрийн үр нөлөөг урьдчилан тооцоолох боломжийг олгодог, удирдлагын шийдвэр гаргалтыг дэмждэг арга зүй юм.

Иймд энэхүү судалгааны хүрээнд улсын нэгдсэн төсвийн орлогод уул уурхайн салбарын эзлэх хувь, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох зорилго тавьсан болно. “Vensim”, “Excel” программыг ашиглан цуглуулсан мэдээллийг боловсруулан, нэгтгэж, судалгааны гол үзүүлэлтүүдийн бүтцийг тодорхойлж, загварын параметрүүдэд анализ хийх, динамик өөрчлөлт, харилцан хамаарлыг тайлбарлах, үр дүнг тооцох ажлыг хийж гүйцэтгэлээ. Судалгааг Үндэсний статистикийн хорооны www.1212.mn цахим мэдээллийн сан, Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчдийн газраас гаргасан “Эрдэс баялгийн салбарын бүтээгдэхүүний 2025 оны тойм судалгаа”-ны статистик мэдээлэл зэргийг ашиглаж гүйцэтгэсэн болно. “Vensim” программ дээр хийсэн уул уурхайн татварын динамик судалгааны үр дүнг дараах зурагт нэгтгэн харууллаа.

Зураг 14. Уул уурхайн салбарын татварын орлогын систем динамикийн загвар



Хүснэгт 9. Уул уурхайн татварын орлогын динамик судалгааны үр дүн


№	Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025	2026	2027
1	Уул уурхайн татварын орлогын эзлэх хувь	49.86	49.47	52.67	58.20	49.15	49.64	49.64
2	Уул уурхайн татварын орлогын динамик, тэрбум төгрөг	3845.5	4390.2	7361.7	10061.1	8810.1	8985.06	8985.06
3	Нийт татварын орлогын динамик, тэрбум төгрөг	7712	8873.3	13977	17285.4	17923.2	18098.2	18098.2

Эх сурвалж: Эрдэс баялгийн салбарын бүтээгдэхүүний 2025 оны тойм судалгаа, Том татвар төлөгчдийн газар, хуудас 6

Уул уурхайн салбарын систем динамикийн загвар дээр уул уурхайн татварын орлогын төсөөлөлд зэс, нүүрсний татварын орлогын төсөөлөл, тэдгээрийн биет хэмжээ ба үнийн өөрчлөлт нөлөөлнө, харин АМНАТ өөрчлөгдөхгүй байх нөхцөлөөр тооцоолсон. Уул уурхайн татварын орлогын бодит цуваа нь уул уурхайн татварын орлогын динамик, улсын татварын орлогын бодит цуваа нь нийт татварын орлогын динамикт нөлөөлнө. Эндээс тухайлбал, зэс, нүүрсний үнэ, биет хэмжээ өөрчлөгдөхөд улсын төсөвт уул уурхайн орлогын эзлэх хувь өсөх, буурахыг урьдчилан тодорхойлох, улмаар төсвийн орлогын цаашдын өсөлтийг тооцоолох боломжтой болох юм.


Судалгааны боломжит үр дүн болох хувилбар 1 дээр улсын төсвийн орлогод уул уурхайн татварын орлогын эзлэх хувийн бодит төсөөлөл, хувилбар 2 дээр нүүрсний биет хэмжээ, үнэ өөрчлөгдөхөд уул уурхайн татварын орлогын эзлэх хувийн өөрчлөлт, хувилбар 3 дээр зэсийн биет хэмжээ, үнэ өөрчлөгдөхөд уул уурхайн татварын орлогын эзлэх хувийн өөрчлөлтийг харуулсан болно.

Зураг 15. Хувилбар 1: Улсын төсвийн орлогод уул уурхайн татварын орлогын эзлэх хувь, уул уурхайн бүтээгдэхүүний биет хэмжээ, үнэ өөрчлөгдөөгүй байх үеийн төсөөлөл



Хувилбар 1 дээр улсын төсвийн орлогод уул уурхайн татварын орлогын эзлэх хувийн бодит төсөөллийг харуулсан байна.


Зураг 16. Хувилбар 2: Улсын төсвийн орлогод уул уурхайн татварын орлогын эзлэх хувь, нүүрсний биет хэмжээ, үнэ өөрчлөгдөх нөхцөл



А. Нүүрсний биет хэмжээ 15 хувиар өссөн тохиолдолд төсвийн орлогод уул уурхайн татварын эзлэх хувь 2027 онд улаан графикийн хэмжээгээр буюу 52 хувь болж өснө.

Б. Нүүрсний үнэ 15 хувь буурсан тохиолдолд төсвийн орлогод уул уурхайн татварын орлогын эзлэх хувь цэнхэр графикийн дагуу буюу 48 хувь болж буурахаар байна.

Зураг 17. Хувилбар 3: Улсын төсвийн орлогод уул уурхайн татварын орлогын эзлэх хувь, зэсийн биет хэмжээ, үнэ өөрчлөгдөх нөхцөл



А. Зэсийн биет хэмжээ 15 хувь өссөн тохиолдолд төсвийн орлогод уул уурхайн татварын орлогын эзлэх хувь 2027 онд улаан графикийн хэмжээгээр буюу 52 хувь болж өснө.

Б. Зэсийн үнэ 15 хувь өссөн тохиолдолд төсвийн орлогод уул уурхайн татварын орлогын эзлэх хувь цэнхэр графикийн дагуу буюу 53 хувь болж өснө.

Дээрх судалгааг нэгтгэн дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Загварын хувилбар 1 дээр төсвийн орлогод уул уурхайн татварын орлогын эзлэх бодит төсөөллийг харуулсан. Хувилбар 2 дээр хэрэв нүүрсний биет хэмжээ 15 хувь өсвөл төсвийн орлогод уул уурхайн татварын эзлэх жин 2027 онд 52 хувьд хүрэх буюу төлөвлөсөн дүнгээс ойролцоогоор 427.17 тэрбум төгрөгөөр өсөх, нүүрсний үнэ 15 хувь буурсан тохиолдолд төсвийн орлогод уул уурхайн орлогын эзлэх жин 48 хувьд хүрэх буюу төлөвлөсөн дүнгээс 296.84 тэрбум төгрөгөөр буурахыг харуулж байна. Мөн зэсийн биет хэмжээ 15 хувь өссөн тохиолдолд төсвийн орлогод уул уурхайн татварын эзлэх жин 52 хувьд хүрч, төлөвлөсөн дүнгээс ойролцоогоор 427.17 тэрбум төгрөгөөр өсөх, харин зэсийн үнэ 15 хувь өссөн тохиолдолд төсвийн орлогод уул уурхайн татварын эзлэх жин 53 хувьд хүрч, төлөвлөсөн дүнгээс 608.17 тэрбум төгрөгөөр өсөхийг илтгэж байгаа юм.

5. МОНГОЛ УЛСЫН 2027 ОНЫ ТӨСӨВТ УУЛ УУРХАЙН САЛБАРААС ТӨВЛӨРӨХ ОРЛОГО, ТҮҮНИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙГ ХАНГАХАД АНХААРАХ АСУУДАЛ

Орчин үед олон улсын тогтолцоо хурдтай өөрчлөгдөн шинэчлэгдэж, нийгэм, эдийн засаг, цэрэг улс төрийн асуудлуудтай холбоотойгоор улс орнуудын харилцаа холбоо, орон зай, цаг хугацааны хамаарал хувьсан өөрчлөгдөж, дэлхийн тодорхой бус байдлын индекс өсөж байгаа учраас манай улсын төсвийн төлөвлөлтийг бодит тооцоо, судалгаа болон эрсдэлийг тооцсон таамаглалд үндэслэн боловсруулах шаардлагатай байна. Иймд Монгол Улсын 2027 оны төсөвт уул уурхайн салбараас төвлөрөх орлого, түүний төлөвлөлтийг бодитой болгохын тулд дараах асуудлыг анхаарах хэрэгтэй. Үүнд:

1. Дэлхийн геополитикийн нөхцөл байдал өөрчлөгдөн, олон улсын харилцааны зөрчилдөөнт байдал нэмэгдэж, тодорхой бус байдлын индекс өсөж байгаа учраас гадаад хүчин зүйлийн нөлөөлөл, үр дагаврыг сайтар үнэлж, төсвийг оновчтой, бодитой төлөвлөх,
2. Геополитикийн зөрчил, БНХАУ, ОХУ-ын нийгэм, эдийн засаг, цэрэг, улс төрийн нөхцөл байдал, Хятадын түүхий эд, нүүрс, зэсийн эрэлт, нийлүүлэлт, зах зээлийн үнэ, шатахууны нийлүүлэлт, валютын ханш зэрэг хүчин зүйлсийг тооцож, нүүрс, зэсийн үнийг суурь, бууралттай, өсөлттэй гурван хувилбараар тооцоолон дунджилж төсвийн төслийг боловсруулах,
3. Манай улсын экспортын хэмжээ, тээвэрлэлт, боомтын хүчин чадал, хилийн нэвтрүүлэх чадварыг бодитой тооцоолох, Хятадын худалдан авалт, нүүрс, зэсийн чанар болон агуулахын нөөцийг хамтад нь тооцоолж төсвийн орлогыг төлөвлөх,
4. Сүүлийн жилүүдэд аж ахуйн нэгжийн татварын орлого, төрийн өмчийн аж ахуйн нэгжийн ногдол ашиг төлөвлөсөн дүнгээс бага байгаа учраас татварын ба татварын бус орлогыг эдийн засгийн бодит нөхцөлтэй уялдуулан тооцож, орлого, ногдол ашгийн төлөвлөгөөг бодит мөнгөн урсгалаар баталгаажуулах, Ойрх Дорнодын мөргөлдөөний хурцадмал байдал үргэлжилж газрын тосны үнэ өсвөл манай улсын аж ахуйн нэгжүүдийн орлого буурахад нөлөөлж болзошгүй байгааг анхаарах,
5. Дэлхийн зах зээлийн үнийг хэт өөдрөгөөр тооцох нь эрсдэлтэй байгаа тул гадаад, дотоод хүчин зүйлээс хамаарч төсвийн орлогын төлөвлөгөө тасалдахад авах арга хэмжээний хувилбартай байх,
6. Төсвийн орлого уул уурхайн салбараас хэт хамааралтай байгаа нь цаашдын орлого бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлөх магадлалтай байгааг анхаарах шаардлагатай юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Buijs, Bram, Henrike Sievers, and Luis A. Tercero Espinoza, "Limits to the Critical Raw Materials Approach" Resources, Conservation and Recycling 65 (2012)
2. Schrijvers, Dieuwertje, Alessandra Hool, Gian Andrea Blengini, Wei-Qiang Chen, Johannes Dewulf, Roderick Eggert, Layla van Ellen, et al, "A Review of Methods and Data to Determine Raw Material Criticality," Resources, Conservation and Recycling 2020: 104617.
3. John Stephenson, The Little Book of Commodity Investing, 2010
4. World Bank, Commodity Markets Outlook, World Bank - Commodity Markets: Evolution, Challenges, and Policies
5. Ашигт малтмал, газрын тосны газар, Статистик мэдээ, 2026 он, https://mrpam.gov.mn/news/
6. Эдийн засаг, хөгжлийн яам, "Макро эдийн засгийн 2025, 2026 оны танилцуулга." https://med.gov.mn/report
7. Монгол Улсын Гаалийн ерөнхий газар, Гадаад худалдааны мэдээ. https://customs.gov.mn
8. Үндэсний статистикийн хороо, Монгол Улсын гадаад худалдааны статистик эмхэтгэл 2025, 2026. Улаанбаатар: УСХ,
9. Монгол Улсын 2027 оны төсвийн төслийн баримт бичиг (дэлгэрэнгүй танилцуулга, тооцоолол)
10. Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өгөх дүгнэлт, 2026.09.12
11. Төсвийн мэдээллийн холбогдох цахим хуудаснууд
12. Бусад эх сурвалжууд


ХАВСРАЛТ 1

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, мянган тонн




Гол нэр төрлийн бараа	2020	2021	2022	2023	2024	2025
Зэсийн хүдэр, баяжмал (мян.тн)	1,778,001.85	2,899,857.3	2,734,846.16	2,625,686.37	3,319,118.63	5,832,456.89
Нүүрс (мян.тн)	2,126,575.34	2,774,073.22	6,503,248.16	8,898,451.9	8,697,915.75	5,768,799.47

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, мянган тонн



ХАВСРАЛТ 2

Улсын татварын ба уул уурхайн татварын орлогын бодит цуваа, тэрбум төгрөг



Боловсруулсан: Д.Тунгалаг, Доктор (Ph.D), профессор,
Б.Цэцгээ, Доктор (Sc.D), профессор, С.Цэндбаатар
Дугаарыг эрхэлсэн: Д.Оюунбадам,
ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер
Хянасан: Б.Ундармаа, ННФ-ын судлаач

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ
Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот 14240, Сүхбаатар дүүрэг, Л.Түдэвийн гудамж-5/3
Утас: 976-76113207
Факс: 976-11-324857
Веб: http://www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn